



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А1246

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Насан туршийн
суралцахуйн төвийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сөүл хотын Боловсролын газраас хандивласан нийт 3,927,936.0 (гурван сая есөн зуун хорин долоон мянга есөн зуун гучин зургаа) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн Насан туршийн суралцахуйн төв (Г.Бүрэнмэнд)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Насан туршийн суралцахуйн төв (Г.Бүрэнмэнд)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/216 дугаар тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Баянзүрх дүүргийн Насан туршийн суралцахуйн төв

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэр-лэсэн он	Цанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Зөөврийн компьютер	Samsung	intel core i3	2012	хуучин	ш	1	678,400.00	678,400.00	Сөүл хотын Боловсролын газар	Хандив
2	Суурин компьютер	Daewoo	intel core i5	2023	шинэ	ш	1	3,249,536.00	3,249,536.00		
Нийт хөрөнгийн дүн									3,927,936.00		